



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР



## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА



УЛС АНХАМГААР ХОТ  
2026 ОН

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН  
СУДАЛГАА**

Танилцсан:	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга	Б.Батцэцэг
	Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга	Н.Баярмаа
Хянасан:	Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга	Б.Аз
Тайлан боловсруулсан:	Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн референт	С.Рэгзэн
	Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн төрийн бүтээмжийн асуудал хариуцсан ажилтан	О.Марал
	Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн бодлогын хэрэгжилт, үр дүн хариуцсан ажилтан	О.Отгонбаяр
	Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн олон улсын бодлого, олон улсын байгууллага хариуцсан ажилтан	А.Ганцэцэг

**АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	5
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	8
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ .....	8
УДИРТГАЛ .....	10
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭ ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....	13
1.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	13
1.2.Сэтгэл ханамжийн үнэлгээ .....	16
1.3.Бүлгийн дүгнэлт .....	18
ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....	20
2.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	20
2.2.Сэтгэл ханамжийн үнэлгээ .....	23
2.3.Бүлгийн дүгнэлт .....	34
ГУРАВДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГААНД ХАМРАГДСАН НИЙТ ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....	37
3.1.Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл .....	38
3.2.Сэтгэл ханамжийн үнэлгээ .....	41
3.3.Бүлгийн дүгнэлт .....	53
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГААНД ХАМРАГДСАН НИЙТ ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....	56
4.1.Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл .....	57
4.2.Сэтгэл ханамжийн үнэлгээ .....	60
4.3.Бүлгийн дүгнэлт .....	70
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ .....	72
ХАВСРАЛТ .....	74

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
ХСХС	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
ОЕСД	Organisation for Economic Co-operation and Development буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
IRIM	Independent research institute of Mongolia
БТЯ	Батлан хамгаалах яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЗТЯ	Зам тээврийн яам
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
ССАЖЗЯ	Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
СЯ	Сангийн яам
БЯ	Боловсролын яам
ТЦҮЗГ	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОГ	Ойн газар
УЦУОШГ	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
УГ	Усны газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
СУГ	Соёл, урлагийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ШШЕГ	Шүүх шинжилгээний ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ЗҮЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб

ЭЭХХЗГ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ТатЕГ	Татварын ерөнхий газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
УХГ	Ургамал хамгааллын газар
ХОХГ	Хөрөнгө оруулалт, худалдааны газар
МЭГ	Монополын эсрэг газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ОӨГ	Оюуны өмчийн газар
ҮГА	Үндэсний геологийн алба
ТагЕГ	Тагнуулын ерөнхий газар
ГИХЯ	Гадаадын иргэн харьяатын газар
ТЗГ	Төмөр замын газар

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ, сэтгэл ханамжийн индекс, 7 үзүүлэлтээр .....	17
Хүснэгт 2.Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үзүүлэлт, байгууллагын төрөл, оноо, хувиар.....	17
Хүснэгт 3.Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар .....	23
Хүснэгт 4.Төрийн захиргааны төв байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн ойлгомжтой байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, хариултын тоо болон хариултын нийт дүнд эзлэх хувиар.....	24
Хүснэгт 5.Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шийдвэрлэх шат дамжлагад хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултад эзлэх хувиар.....	24
Хүснэгт 6.Төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчийн харилцаа хандлагад өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувь.....	25
Хүснэгт 7.Төрийн захиргааны төв байгууллагын төрийн албан хаагчийн мэдлэг ур, чадварт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувиар.....	26
Хүснэгт 8.Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултын дүнд эзлэх хувиар.....	27
Хүснэгт 9.Төрийн захиргааны төв байгууллагын үйлчилгээний орчин, нөхцөлд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар.....	28
Хүснэгт 10.Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шийдвэрлэх үйл явц ил тод эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар.....	29
Хүснэгт 11.Төрийн захиргааны төв байгууллагын сэтгэл ханамжийн үзүүлэлт, үзүүлэлт тус бүрээр болон нэгдсэн онооны дундаж оноо, индекс .....	29
Хүснэгт 12.Төрийн захиргааны төв байгууллагаас авсан үйлчилгээнд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, тоо, хувиар.....	30
Хүснэгт 13.Хэрэглэгчдийн төрийн захиргааны байгуулалтын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, тоо, хувиар .....	33
Хүснэгт 14.Агентлагийн үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцож үнэлгээ өгсөн хэрэглэгчийн тоо, байгууллагаар .....	37
Хүснэгт 15.Агентлагийн үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар.....	41
Хүснэгт 16.Агентлагийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийн ойлгомжтой байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, хариултын тоо болон хариултын нийт дүнд эзлэх хувиар.....	42
Хүснэгт 17.Агентлагийн асуудлыг шийдвэрлэх шат дамжлагад хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултад эзлэх хувиар .....	43
Хүснэгт 18.Агентлагийн албан хаагчийн харилцаа хандлагад өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувь .....	44
Хүснэгт 19.Агентлагийн албан хаагчийн мэдлэг ур чадварт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувь .....	45
Хүснэгт 20.Агентлагийн асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултын дүнд эзлэх хувиар.....	46
Хүснэгт 21.Агентлагийн үйлчилгээний орчин, нөхцөлд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар.....	47

Хүснэгт 22.Агентлагийн асуудлыг шийдвэрлэх үйл явц ил тод эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар .....	48
Хүснэгт 23.Агентлагийн сэтгэл ханамжийн үзүүлэлт, үзүүлэлт тус бүрээр болон нэгдсэн онооны дундаж оноо, индекс .....	49
Хүснэгт 24.Агентлагаас авсан үйлчилгээнд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, тоо, хувиар .....	50
Хүснэгт 25.Судалгаанд оролцсон хэрэглэгчдийн агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, тоо, хувиар .....	53
Хүснэгт 26.Аймаг, нийслэлийн үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцож үнэлгээ өгсөн хэрэглэгчийн тоо, байгууллагаар ..	56
Хүснэгт 27.Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар .....	60
Хүснэгт 28.Аймаг, нийслэлийн Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ойлгомжтой байдаг талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, хариултын тоо болон хариултын нийт дүнд эзлэх хувиар.....	61
Хүснэгт 29.Аймаг, нийслэлийн асуудлыг шийдвэрлэх шат дамжлагад хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултад эзлэх хувиар .....	61
Хүснэгт 30.Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын албан хаагчийн харилцаа хандлагад өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувь .....	62
Хүснэгт 31.Аймаг, нийслэлийн төрийн албан хаагчийн мэдлэг ур, чадварт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувиар .....	63
Хүснэгт 32.Аймаг, нийслэлийн асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултын дүнд эзлэх хувиар.....	64
Хүснэгт 33.Аймаг, нийслэлийн үйлчилгээний орчин, нөхцөлд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар .....	64
Хүснэгт 34.Аймаг, нийслэлийн асуудлыг шийдвэрлэх үйл явц ил тод эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоо, нийт хариултад эзлэх хувиар.....	65
Хүснэгт 35.Аймаг, нийслэлийн сэтгэл ханамжийн үзүүлэлт, үзүүлэлт тус бүрээр болон нэгдсэн онооны дундаж оноо, индекс .....	66
Хүснэгт 36.Аймаг, нийслэлийн авсан үйлчилгээнд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, тоо, хувиар.....	66
Хүснэгт 37.Хэрэглэгчдийн аймаг, нийслэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, тоо, хувиар .....	69

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн хүйсийн харьцаа, хувиар .....	14
--	----

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.Судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн тоо, байршлаар .....	13
График 2.Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, насны ангилал, тоо, хувиар	14
График 3.Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, боловсролын зэрэг, тоо, хувиар.....	15
График 4.Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, төлөөлөл, тоо, хувиар.....	15
График 5.Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэлбэр, тоо, хувиар .....	16
График 6.Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хугацаа, тоо, хувиар .....	16
График 7.Үйлчилгээ бүрэн авсан эсэх, хувиар .....	18
График 8.Үйлчилгээ бүрэн авсан хэрэглэгчдийн үйлчилгээний үр дүн, тоо, хувиар	18



График 9.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, хүйс, тоо, хувиар .....	20
График 10.Төрийн захиргааны төв байгууллагын сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, төлөөлөл, тоо, хувиар .....	20
График 11.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, насны бүлэг, тоо, хувиар .....	21
График 12.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, боловсролын түвшнээр, тоо, хувиар .....	21
График 13.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид байршлаар, тоо, хувиар .....	22
График 14.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үйлчилгээ авсан хэлбэр, үйлчилгээ авсан хүний тоо, хувиар.....	22
График 15.Төрийн захиргааны төв байгууллагаас үйлчилгээ авахад зарцуулсан хугацаа, хэрэглэгчийн тоо, хувиар.....	22
График 16.7 үзүүлэлтээр тооцсон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий индекс болон үйлчилгээний үр дүнд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хувиар .....	32
График 17.Агентлагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, хүйсээр, тоо, хувиар .....	38
График 18.Агентлагийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн төрөл, тоо, хувиар.....	38
График 19.Агентлагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчид, боловсролын түвшнээр, тоо, хувиар .....	39
График 20.Агентлагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчид, насны бүлгээр, тоо, хувиар .....	39
График 21.Агентлагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчид, байршлаар.....	40
График 22.Агентлагийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үйлчилгээ авсан хэлбэр, тоо, хувиар.....	40
График 23.Агентлагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн, үйлчилгээ авсан хугацаа, тоо, хувиар .....	41
График 24.үзүүлэлтээр тооцсон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий индекс болон үйлчилгээний үр дүнд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хувиар .....	51
График 25.Хүйсийн харьцаа.....	57
График 26.Аймаг, нийслэлийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн төрөл, тоо, хувиар.....	57
График 27.Аймаг, нийслэлийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, насны бүлгээр, тоо, хувиар.....	58
График 28.Аймаг, нийслэлийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, боловсролын түвшнээр, тоо, хувиар .....	58
График 29.Аймаг, нийслэлийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид байршлаар, тоо, хувиар .....	59
График 30.Аймаг, нийслэлийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үйлчилгээ хэлбэр, хэрэглэгчийн тоо, хувиар.....	59
График 31. Аймаг, нийслэлийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үйлчилгээ авсан хугацаа, хэрэглэгчийн тоо, хувиар .....	59
График 32.7 үзүүлэлтээр тооцсон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий индекс болон үйлчилгээний үр дүнд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хувиар .....	68

## УДИРТГАЛ

Дэлхийн олон улс оронд төрийн үйлчилгээний чанар хүртээмж, иргэдийн сэтгэл ханамж, нээлттэй, ил тод байдлыг хэмжих төрийн байгууллагын үйлчилгээний чанар, иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх олон хэлбэрээр зохион байгуулдаг байна. Судалгаанд дараах хэлбэрүүд өргөнөөр хэрэглэгддэг. Үүнд:

- Цахим судалгаа (web survey);
- Дуудлагын судалгаа (CATI);
- Биечилсэн ярилцлага (Face-to-face CAPI);
- Интернет панель ашиглах (research panel);
- Шуудангаар асуумж илгээх (mail survey);
- Хосолмол арга (mixed method).

Хэдийгээр судалгааны хамрах хүрээ, үзүүлэлт, аргачлал, давтамж, мэдээлэл цуглуулах хэлбэр нь улс орон бүрд өөр боловч нийтлэг зорилго нь иргэдийн үзэл бодлыг бодитоор тусгах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, бодлогын үр нөлөөг хэмжихэд чиглэдэг.

Олон улсын байгууллагууд (OECD, World Bank, UNDP, гэх мэт) төрийн үйлчилгээний үр нөлөө, хариуцлагын тогтолцоо, иргэдийн оролцоо, цахим үйлчилгээний хүртээмж зэрэг олон үзүүлэлтийг бүтцийн болон хэрэглэгч төвтэй судалгааны арга зүйгээр үнэлдэг. Эдгээр байгууллагаас төрийн үйлчилгээ дэх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор зохион байгуулсан зарим судалгааг жишээ болгон доор үзүүлэв.

**OECD – Serving Citizens: Measuring the Performance of Services for a Better User Experience** - Энэхүү судалгаанд төрийн үйлчилгээний хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг хэмжих үзүүлэлтүүдийг судалж, үйлчилгээний чанар, хүртээмж, хариу үйлдэл зэрэг хүчин зүйлсийг үнэлэх арга зүйг танилцуулсан.

**World Bank: Service Delivery Indicators (SDI)** - Дэлхийн Банкны SDI хөтөлбөр нь боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанарыг хэмжихэд чиглэсэн бөгөөд үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг үнэлэхэд ашиглагддаг.

**UNDP: Governance Indicators: A User's Guide** - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулсан энэхүү гарын авлага нь засаглалын үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлох, хэмжих, үнэлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг.

Улс орнуудын туршлагаас харахад (Хавсралт 1), төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа нь үндэсний түвшинд тогтмол хийгдэх шаардлагатай, бодлогын чухал хэрэгсэл болох нь тодорхой байна. Түүнчлэн, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэх, үйлчилгээ авах үйл явц иргэдийн хувьд ойлгомжтой, шударга, хүндрэл багатай байгаа эсэхийг тогтмол үнэлэх шаардлага нэмэгдсэнтэй холбоотойгоор олон улс орон төрийн үйлчилгээний хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг институтийн түвшинд тогтмол зохион байгуулж, шинжлэх ухаанч арга зүйгээр хэрэгжүүлэх чиг хандлагатай байна.

## **Судалгааны үндэслэл**

Төрийн үйлчилгээ нь хууль тогтоомжийн хүрээнд хүний эрх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төрийн байгууллагуудаас үзүүлдэг үндсэн үйл ажиллагаа бөгөөд иргэдийн өдөр тутмын амьдрал, амьжиргааны чанарт шууд нөлөөлдөг учир төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ дэх иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх нь үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, үр дүнг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.

Сүүлийн жилүүдэд төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хялбаршуулах, цахимжуулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч, үйлчилгээний чанар, байгууллагын хандлага, мэдээллийн ил тод байдал зэрэг хүчин зүйлс нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлсөөр байна.

Төрийн бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол зохион байгуулж, судалгааны үр дүнг төрийн үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тэдний оролцоог дэмжих, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд ашиглах ёстой.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсэгт “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг жил бүр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар зохион байгуулна” гэж заасан.

Иймд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас төрийн захиргааны төв, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тандах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

## **Судалгааны зорилго**

Энэхүү судалгааны зорилго нь төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдал дахь хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамжийг тодорхойлж, цаашид сайжруулах шаардлагатай үйлчилгээний талаар санал, зөвлөмж боловсруулах, төрийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээнд ашиглах мэдээллийг бүрдүүлэхэд оршино.

## **Судалгааны арга зүй**

Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээний талаарх үндэсний болон олон улсын тайлан, баримт материалыг судалж, энэхүү судалгааны арга зүй, асуулгыг боловсрууллаа.

Судалгаанд оролцогчид: Судалгааны эх олонлогийг тухайн хугацаанд төрийн үйлчилгээ авсан хэрэглэгчид гэж тодорхойлж, тэдгээрээс санамсаргүй байдлаар судалгаанд оролцсон хэрэглэгчид түүврийг бүрдүүлсэн. Судалгаанд оролцогчдыг урьдчилан ялгаварлахгүйгээр, боломжит бүх хэрэглэгчдэд тэгш боломж олгох зарчмыг баримталсан.

Мэдээлэл цуглуулах арга: Энэхүү судалгааны мэдээллийг цахим асуулгын аргаар цуглуулав. Оролцогчид өөрийн цаг хугацаа, боломжид нийцүүлэн асуулгад хариулснаар мэдээллийг богино хугацаанд, өргөн хүрээгээр цуглуулах боломжтой болсон.

Судалгааны асуумжийн цахим холбоосыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, үнэлгээнд хамрагдах төрийн байгууллагын цахим хуудас, фейсбүүк, мэдээллийн сайтуудад байрлуулж, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн холбоотой хамтран ажиллаж, гишүүдийг нь судалгаанд хамрагдахыг уриалсан.

Өгөгдөл боловсруулах арга: Судалгаанд хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хэмжихдээ 5 шатлалт Likert-ийн үнэлгээний аргыг ашигласан бөгөөд нэмэлтээр “0 – Мэдэхгүй” гэсэн сонголтыг оруулсан. Судалгаанд ашигласан хариултын сонголт нь дараах утгыг илэрхийлнэ:

- 0 – Мэдэхгүй;
- 1 – Сэтгэл ханамжгүй;
- 2 – Сэтгэл ханамж багатай;
- 3 – Сэтгэл ханамж дунд;
- 4 – Сэтгэл ханамжтай;
- 5 – Сэтгэл ханамж маш өндөр.

“Мэдэхгүй” гэсэн хариултыг тухайн асуултад тодорхой үнэлгээ өгөх боломжгүй тохиолдолд сонгох бөгөөд энэхүү хариултыг сэтгэл ханамжийн тоон үнэлгээнд оруулахгүйгээр, тусад нь ангилан авч үзсэн.

Цуглуулсан мэдээллийг нэгтгэн боловсруулж, статистик шинжилгээ хийсэн. Өгөгдлийг цэвэрлэх, кодлох, ангилах үйлдлүүдийг гүйцэтгэсний дараа давтамж, хувь хэмжээ, дундаж утга зэрэг үзүүлэлтүүдийг тооцсон. Мөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий түвшнийг нэгтгэн илэрхийлэх зорилгоор сэтгэл ханамжийн индекс (Customer Satisfaction Index)-ийг дараах томъёогоор тооцсон. Уг томъёогоор Likert-ийн үнэлгээний дундаж утгыг 0–100 онооны шкалд хөрвүүлэн илэрхийлсэн болно.

$$\text{Сэтгэл ханамжийн индекс (СНІ)} = (\text{Нийт дундаж оноо} / 5) \times 100.$$

Индексийн ангилал:

- 4.50-5.00 буюу 90-100 хувь байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай.
- 3.50-4.49 буюу 70-89 хувь байвал хэрэглэгч сэтгэл ханамжтай бөгөөд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэсэн үзүүлэлт юм.
- 2.50-3.49 буюу 50-69 хувь бол дунд сэтгэл ханамжтай ба цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- 1.50-2.49 буюу 30-49 хувь байхад хэрэглэгчид сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд цаашид яаралтай сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- 1.49 буюу 29 хувиас доош байгаа бол энэ нь хэрэглэгчид огт сэтгэл ханамжгүй, маш хангалтгүй байгааг тус тус илэрхийлнэ.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тоон утга болон хувиар тооцсон индексээр илэрхийлж, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын дундаж болон байгууллага бүрээр харьцуулж дүгнэнэ.

Судалгааны асуулга: Судалгааны асуулга нь дараах 2 хэсэгтэй. Үүнд:

- I.Ерөнхий мэдээлэл: Үнэлгээ хийх байгууллагын болон хэрэглэгчийн төрөл, үнэлгээнд оролцох шалтгаан
- II.Хэрэглэгчийн мэдээлэл: Нас, хүйс, байршил, боловсролын түвшин
- III.Хэрэглэгчийн сэтгэл ханамж. Үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний чанар, Асуудлыг шийдвэрлэсэн хугацаа, шуурхай байдал, албан хаагчийн харилцаа, ур чадвар, хандлага, ёс зүй, сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭ ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ**


Судалгаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, 16 яам, 40 агентлаг, бүх аймгийн болон нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үйлчилгээ авсан 8,554 хэрэглэгч хамрагдсан юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2026 оны 02 дугаар сарын 23-аас 02 дугаар сарын 28-ны хооронд Microsoft Form программ ашиглан цахимаар зохион байгууллаа.

#### **1.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл**


Судалгаанд оролцсон хэрэглэгчдийг байршлаар нь харвал 4,372 хэрэглэгч буюу 51.1 хувь нь Улаанбаатар хотоос, 2,057 хэрэглэгч буюу 24.0 хувь аймгийн төвөөс, 1,498 хэрэглэгч буюу 17.5 хувь нь сумын төвөөс оролцжээ. Харин хөдөөгөөс (434 хэрэглэгч буюу 5.1 хувь) болон гадаад улсад амьдарч байгаа (193 хэрэглэгч буюу 2.3 хувь) хэрэглэгч цөөн хамрагдсан байна.

График 1.Судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн тоо, байршлаар




Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 41.4 хувь (3,538) нь эрэгтэй, 58.6 хувь (5,016) нь эмэгтэй байв.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн хүйсийн харьцаа, хувиар




Сэтгэл ханамжийн судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 52.9 хувь нь 30–44, 25.6 хувь нь 45-аас дээш, 20.4 хувь нь 20-29, 1.1 хувь нь 19-өөс доош насныхан байна.

График 2. Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, насны ангилал, тоо, хувиар




Судалгаанд оролцогчдын 69.7 хувь нь бакалавр ба түүнээс дээш түвшний боловсролтой, 12.7 хувь нь мэргэжлийн болон техникийн, дипломын дээд боловсролтой байна. Бүрэн дунд болон түүнээс доош түвшний боловсролтой 1495 (17.5 хувь), боловсролгүй 9 хэрэглэгч (0.1 хувь) оролцсон байна.

График 3. Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, боловсролын зэрэг, тоо, хувиар




Сэтгэл ханамжийн судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 53.8 хувь нь тухайн байгууллагатай холбоотой ажилладаг төрийн байгууллагын төлөөлөл, 38.4 хувь нь иргэд, 5.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 2.3 хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

График 4. Сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, төлөөлөл, тоо, хувиар



Хэрэглэгчдийн 41.6 хувь нь биечлэн очиж үйлчилгээ авсан бөгөөд 31.3 хувь нь цахимаар, 13.9 хувь нь албан бичгээр хандаж, 5.3 хувь нь телефон утсаар, 7.9 хувь нь бусад хэлбэрээр үйлчилгээ авчээ.


График 5. Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэлбэр, тоо, хувиар



Үйлчилгээ авсан хэрэглэгчдийн 43.3 хувь нь тухайн үедээ, 16.1 хувь нь ажлын 1 өдөрт, 19.9 хувь нь 5 өдөрт багтаан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

Мөн 9.0 хувь нь ажлын 10-15 өдөрт, 11.7 хувь хуанлийн 30 ба түүнээс дээш хоногт үйлчилгээ авч дуусжээ.

График 6. Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хугацаа, тоо, хувиар



## 1.2. Сэтгэл ханамжийн үнэлгээ

Улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 80 байгууллагын үйл ажиллагааг хэрэглэгчид 3.7 оноогоор “Дунд” гэж үнэлсэн ба ерөнхий сэтгэл ханамжийн индекс 73.8 хувь байна.

Хариултын тархалтаас харахад “сэтгэл ханамжтай” болон “сэтгэл ханамж маш өндөр” гэсэн үнэлгээний нийлбэр дунджаар 55 гаруй хувийг эзэлж байгаа бол “сэтгэл ханамж дунд” 18.7 хувь, “сэтгэл ханамж багатай” 11.6 хувь, “огт санал нийлэхгүй” 8.7 хувь, “мэдэхгүй” 5.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ, сэтгэл ханамжийн индекс, 7 үзүүлэлтээр

Байгууллагын нэр	НИЙТ	Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ойлгомжтой байдал		Асуудлыг шийдвэрлэх шат дамжлага цөөн		Төрийн албан хаагчийн харилцаа хандлага сайн		Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар сайн		Асуудлыг шударга шийдвэрлэдэг		Үйлчилгээний орчин, нөхцөл сайн		Асуудлыг шийдвэрлэх үйл явц илтөд		НИЙТ		Байгууллагаас авсан үйлчилгээний үр дүнд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	
		үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ	үнэлгээ	СХИ
Төрийн захиргааны төв байгууллага	2302	3.3	66.3	3.1	62.3	3.4	67.7	3.5	69.4	3.3	66.3	3.5	69.9	3.3	65.3	3.3	66.7	3.8	75.3
Агентлаг	3277	3.7	74.5	3.6	72.4	3.8	75.2	3.8	76.3	3.7	72.0	3.8	75.5	3.7	73.5	3.7	74.5	3.8	76.9
Аймаг, нийслэл	2975	3.7	74.6	3.6	72.0	3.7	73.4	3.8	75.2	3.6	72.6	3.8	77.0	3.6	72.1	3.7	73.8	3.6	72.5
НИЙТ	8554	3.6	71.8	3.4	68.9	3.6	72.1	3.7	73.6	3.5	70.3	3.7	74.1	3.5	70.3	3.6	71.7	3.7	74.9

Сэтгэл ханамжийн индексийг үзүүлэлт тус бүрээр харвал төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар-73.6 хувь, үйлчилгээний орчин, нөхцөл-73.6 хувь байгаа нь өндөр байна.


Харин асуудлыг шийдвэрлэх шат дамжлагыг 71.2 хувиар үнэлсэн нь эдгээр үзүүлэлтийн хамгийн бага үнэлгээ болж байна.

Хүснэгт 2.Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үзүүлэлт, байгууллагын төрөл, оноо, хувиар

ҮЗҮҮЛЭЛТ	Төрийн захиргааны төв байгууллага		Агентлаг	Аймаг, нийслэл	НИЙТ
Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ойлгомжтой байдал	үнэлгээ	3.3	3.7	3.7	3.7
	СХИ	66.3	74.5	74.6	74.5
Асуудлыг шийдвэрлэх шат дамжлага цөөн	үнэлгээ	3.1	3.6	3.6	3.6
	СХИ	62.3	72.4	72.0	71.2
Төрийн албан хаагчийн харилцаа хандлага сайн	үнэлгээ	3.4	3.8	3.7	3.7
	СХИ	67.7	75.2	73.4	73.9
Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар сайн	үнэлгээ	3.5	3.8	3.8	3.8
	СХИ	69.4	76.3	75.2	75.6
Асуудлыг шударга шийдвэрлэдэг	үнэлгээ	3.3	3.7	3.6	3.7
	СХИ	66.3	72.0	72.6	73.1
Үйлчилгээний орчин, нөхцөл сайн	үнэлгээ	3.5	5.9	3.8	3.8
	СХИ	69.9	73.8	77.0	76
Асуудлыг шийдвэрлэх үйл явц илтөд	үнэлгээ	3.3	5.4	3.6	3.6
	СХИ	65.3	72.7	72.1	72.47
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ИНДЕКС	үнэлгээ	3.3	3.7	3.7	3.6
	СХИ	66.7	74.5	73.8	71.7
Байгууллагаас авсан үйлчилгээний үр дүнд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	үнэлгээ	3.8	3.8	3.6	3.8
	СХИ	75.3	76.9	72.5	74.9
<b>Судалгаанд оролцсон хэрэглэгчийн тоо</b>		<b>2302</b>	<b>3277</b>	<b>2975</b>	<b>8554</b>

Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэрэглэгчдийн 81.1 хувь нь үйлчилгээг бүрэн авч дууссан гэж хариулсан бол 18.9 хувь нь үйлчилгээг бүрэн авч дуусгаагүй гэж хариулсан байна.


График 7. Үйлчилгээ бүрэн авсан эсэх, хувиар



Үйлчилгээг бүрэн авсан хэрэглэгчдийн үйлчилгээ үр дүнтэй байсан эсэхийг тодруулахад үйлчилгээ бүрэн авсан хэрэглэгчдийн 49.3 хувь нь “үр дүнтэй”, 18.6 хувь нь “үр дүн маш өндөр” гэж үнэлсэн байна.

Харин 1153 хэрэглэгч хэрэглэгч буюу 16.9 хувь нь “үр дүн дунд”, 574 хэрэглэгч буюу 8.4 хувь нь “үр дүн багатай”, нь 188 хэрэглэгч буюу 2.7 хувь нь “үр дүнгүй” гэж үнэлсэн байна. “Мэдэхгүй” гэж хариулсан хэрэглэгч 4.0 хувь буюу 276 байна.

График 8. Үйлчилгээ бүрэн авсан хэрэглэгчдийн үйлчилгээний үр дүн, хувиар



Эдгээр үзүүлэлтийг нэгтгэн тооцоход хэрэглэгчийн сэтгэл ханамжийн улсын дундаж индекс 71.76 хувь байгаа нь нийт үнэлгээ “дунджаас дээш” түвшинд байна.

### 1.3. Бүлгийн дүгнэлт

Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд нийт 8,554 хэрэглэгч хамрагдсан бөгөөд байршлын хувьд 51.1 хувь нь Улаанбаатар хот, 24.0 хувь нь аймгийн төв, 17.5 хувь нь сумын төвөөс оролцсон байна. Насны бүлгийн хувьд 30–44 насны ангилал 52.9 хувийг эзэлж байгаа нь идэвхтэй хөдөлмөрийн насны бүлэг үйлчилгээний үндсэн хэрэглэгч байгааг харуулж байна.

Боловсролын зэргээр авч үзвэл бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй хэрэглэгчид 69.7 хувь байгаа нь төрийн үйлчилгээний хэрэглэгчдийн дийлэнх нь өндөр боловсролтой байгааг илтгэж байна. Үйлчилгээ авсан хэлбэрийн хувьд 41.6 хувь нь биечлэн, 31.3 хувь нь цахимаар үйлчилгээ авсан нь уламжлалт болон цахим үйлчилгээ зэрэгцэн ашиглагдаж байгааг харуулж байна.

Үйлчилгээ авсан хугацааны хувьд 43.3 хувь нь үйлчилгээ авахаар очсон тухайн үедээ газар дээр нь авсан бол 16.1 хувь нь 1 өдрийн дотор, 19.9 хувь нь 5 өдрийн дотор асуудлаа шийдвэрлүүлсэн бол 11.7 хувь нь 30 ба түүнээс дээш хоног зарцуулсан нь үйлчилгээ авах хугацаанд ялгаатай байгааг илэрхийлж байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээгээр нийт дундаж үнэлгээ 3.7, сэтгэл ханамжийн индекс 73.8 хувь байгаа нь “дунджаас дээш” түвшинд үнэлэгдэж байна. Үүнээс төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар болон үйлчилгээний орчин нөхцөл 73.6 хувьтай өндөр үнэлэгдсэн бол асуудлыг шийдвэрлэх шат дамжлага 71.2 хувьтай хамгийн бага үнэлгээ авсан байна.

Мөн хэрэглэгчдийн 81.1 хувь нь үйлчилгээг бүрэн авч дууссан гэж хариулсан бөгөөд тэдгээрийн 49.3 хувь нь үйлчилгээний үр дүнг “үр дүнтэй”, 18.6 хувь нь “үр дүн маш өндөр” гэж үнэлсэн нь үйлчилгээний үр дүнгийн эерэг үнэлгээ давамгайлж байгааг харуулж байна.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ бүлэгт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон яамд (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх)-ын үйл ажиллагаанд хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ, сэтгэл ханамжийн индексийн талаар танилцуулна.

### 2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Төрийн захиргааны төв байгууллагын үйлчилгээ дэх сэтгэл ханамжийн судалгаанд нийт 2302 хүн хамрагдсан байна. Хэрэглэгчдийн 57 хувь нь эрэгтэй, 43 хувь нь эмэгтэй байна.

График 9.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, хүйс, тоо, хувиар




Судалгаанд хамрагдсан оролцогчийн 53 хувь нь буюу 1,221 нь тухайн байгууллагаас үйлчилгээ авдаг бусад төрийн байгууллагын ажиллагч, 40 хувь буюу 913 нь иргэн, 5 хувь буюу 119 нь аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 2 хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл бөгөөд иргэдийн оролцоо өндөр, харин аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын оролцоо бага байлаа.

График 10.Төрийн захиргааны төв байгууллагын сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, төлөөлөл, тоо, хувиар




График 11.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, насны бүлэг, тоо, хувиар



Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 19.2 хувь (443 хэрэглэгч) нь 35-39 насныхан байгаа бол 20-24, 25-29, 30-34, 40-44, 45-49 насны бүлгийн төлөөлөл тус бүр 10-аас дээш хувийг бүрдүүлсэн байна. Харин 16 хүртэлх, 17-19 болон 60-аас дээш насны бүлгийн төлөөлөл хамгийн бага хамрагджээ.


Судалгаанд оролцогчдын 47.8 хувь (1100 хүн) нь бакалаврын, 18.0 хувь (431) нь магистр, докторын түвшний боловсролтой байгаа нь нийт оролцогчдын 65.8 хувь буюу дийлэнхийг нь бүрдүүлж байна. Харин мэргэжлийн болон техникийн боловсролтой 9.0 хувь (207), бүрэн дунд боловсролтой 19.2 хувь (443) нь, суурь боловсролтой 0.4 хувь (10), бага боловсролтой 0.6 хувь (13), боловсролгүй 0.1 хувь (2) буюу нийт оролцогчдын 29.3 хувь нь болж байна.

График 12.Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид, боловсролын түвшнээр, тоо, хувиар




Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн дийлэнх буюу 69.2 хувь нь Улаанбаатар хотоос, 13.0 хувь нь аймгийн төвөөс, 11.4 хувь нь сумын төвөөс, 4.5 хувь нь хөдөөгөөс оролцсон байна. Түүнчлэн гадаад улсаас 44 хүн (1.9 хувь) хэрэглэгч судалгаанд оролцжээ.

График 13. Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчид байршлаар, тоо, хувиар




Судалгаанд хамрагдсан хэрэглэгчид ихэвчлэн цахим болон биеэр үйлчилгээ авсан байна. Тухайлбал, цахимаар үйлчилгээ авсан оролцогчид нийт оролцогчдын 36.1 хувь, биеэр үйлчилгээ авсан оролцогчид 33.5 хувь нь байна. Харин албан бичгээр, утсаар болон бусад хэлбэрээр үйлчилгээ авсан иргэд бага буюу 13.8, 5.6, 11 хувийг тус тус эзэлж байна.

График 14. Төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үйлчилгээ авсан хэлбэр, үйлчилгээ авсан хүний тоо, хувиар



Мөн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдэд биеэр буюу уламжлалт хэлбэрээр үйлчилгээ авсан хэрэглэгчийн эзлэх хувь өндөр байна. Харин утсаар үйлчилгээ авсан хэрэглэгчид бага байна.

График 15. Төрийн захиргааны төв байгууллагаас үйлчилгээ авахад зарцуулсан хугацаа, хэрэглэгчийн тоо, хувиар



Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн төрийн захиргааны төв байгууллагаас үйлчилгээ авахад зарцуулсан хугацааг тодруулахад, оролцогчдын хамгийн их буюу 39.4 хувь нь үйлчилгээг тухайн өдөрт нь авч чадсан гэж хариулсан. Мөн 1 (14.2 хувь) болон ажлын 5 өдрийн дотор (21.2 хувь) үйлчилгээ авсан иргэдийн хувь өндөр байгаа нь төрийн захиргааны төв байгууллагууд дийлэнх тохиолдолд үйлчилгээг “шуурхай” хүргэж байгааг илтгэж байна. Харин хэрэглэгчдийн 14.6 хувь нь асуудлаа шийдвэрлүүлэхэд хуанлийн 30 болон түүнээс дээш хоногийн хугацааг зарцуулжээ.

## 2.2. Сэтгэл ханамжийн үнэлгээ

Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд тухайн байгууллагаас үйлчилгээ авсан/авч байгаа хэрэглэгчийн сэтгэл ханамжийг 7 үзүүлэлтээр үнэлсэн.

Судалгаанд хамрагдсан 18 байгууллагын үйл ажиллагааг хэрэглэгчид 3.3 оноогоор “Дунд” гэж үнэлсэн ба ерөнхий сэтгэл ханамжийн индекс 66.7 хувь байна.

Хүснэгт 3.Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар

Үзүүлэлт	Нийт	Мэдэхгүй-0		Огт санал нийлэхгүй-1		Сэтгэл ханамж багатай-2		Сэтгэл ханамж дунд-3		Сэтгэл ханамжтай-4		Сэтгэл ханамж маш өндөр-5		Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ойлгомжтой байдаг	2302	171	7.4	261	11.3	396	17.2	452	19.6	315	13.7	707	30.7	3.3	66.3
Асуудлыг шийдвэрлэх шат дамжлага цөөн	2302	179	7.8	337	14.6	407	17.7	527	22.9	216	9.4	591	25.7	3.1	62.3
Төрийн албан хаагчийн харилцаа хандлага сайн	2302	125	5.4	250	10.9	352	15.3	505	21.9	320	13.9	743	32.3	3.4	67.7
Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар сайн	2302	153	6.6	215	9.3	326	14.2	507	22.0	327	14.2	779	33.8	3.5	69.4
Асуудлыг шуударга шийдвэрлэдэг	2302	164	7.1	305	13.2	332	14.4	490	21.3	297	12.9	714	31.0	3.3	66.3
Үйлчилгээний орчин, нөхцөл сайн	2302	158	6.9	223	9.7	323	14.0	520	22.6	311	13.5	767	33.3	3.5	69.9
Асуудлыг шийдвэрлэх үйл явц ил тод	2302	171	7.4	342	14.9	334	14.5	465	20.2	281	12.2	708	30.8	3.3	65.3
<b>НИЙТ</b>	-	-	<b>7.0</b>	-	<b>12.0</b>	-	<b>15.3</b>	-	<b>21.5</b>	-	<b>12.8</b>	-	<b>31.1</b>	<b>3.3</b>	<b>66.7</b>

Судалгаанд оролцогчдын хариултад “сэтгэл ханамжтай” болон “маш сайн” үнэлгээ зонхилж байгаа ч, “дунд” болон “бага” үнэлгээний хувь өндөр хэвээр байна. Энэ нь үйлчилгээний чанар тогтвортой бус, зарим чиглэлд сайжруулалт шаардлагатайг илтгэнэ. Иймд цаашид үйлчилгээний шат дамжлагыг хялбаршуулах, шийдвэрлэх үйл явцыг ил тод болгох, хэрэглэгчид шуурхай дэмжлэг үзүүлэхэд анхаарах нь зүйтэй.

### Үйлчилгээтэй холбоотой мэдээллийн ойлгомжтой эсэхэд хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ

Эдгээр байгууллагын “үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ойлгомжтой байдал”-ыг (Зураг 4) хэрэглэгчид дунджаар 3.3 буюу “Дунд” гэж үнэлсэн бөгөөд сэтгэл ханамжийн индекс 66.3 хувь байна.

Хүснэгт 4.Төрийн захиргааны төв байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн ойлгомжтой байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, хариултын тоо болон хариултын нийт дүнд эзлэх хувиар

	Байгууллагын нэр	Нийт	Хариулт												Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
			Мэдэхгүй-0		ОГ санал нийлэхгүй-1		Сэтгэл ханамж багатай-2		Сэтгэл ханамж дунд-3		Сэтгэл ханамжтай-4		Сэтгэл ханамж маш өндөр-5			
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	БХЯ	336	31	9.2	11	3.3	37	11.0	79	23.5	45	13.4	133	39.6	3.8	76.5
2	ХЗДХЯ	360	41	11.4	20	5.6	42	11.7	62	17.2	53	14.7	142	39.4	3.8	76.0
3	ХХААХҮЯ	97	2	2.1	6	6.2	17	17.5	19	19.6	14	14.4	39	40.2	3.7	73.3
4	ГБХНХЯ	154	9	5.8	19	12.3	20	13.0	23	14.9	26	16.9	57	37.0	3.6	71.3
5	ГХЯ	27	1	3.7	5	18.5	3	11.1	3	11.1	4	14.8	11	40.7	3.5	70.0
6	ЦХИХХЯ	45	2	4.4	8	17.8	5	11.1	5	11.1	8	17.8	17	37.8	3.5	69.8
7	БОУАӨЯ	82	4	4.9	8	9.8	15	18.3	15	18.3	12	14.6	28	34.1	3.5	69.5
8	ЗГХЭГ	43	0	0.0	2	4.7	9	20.9	11	25.6	11	25.6	10	23.3	3.4	68.4
9	ЗГХХГ	60	3	5.0	6	10.0	12	20.0	13	21.7	7	11.7	19	31.7	3.4	67.4
10	ЭТЯ	84	7	8.3	9	10.7	16	19.0	14	16.7	14	16.7	24	28.6	3.4	67.3
11	АҮЭБЯ	65	9	13.8	5	7.7	10	15.4	13	20	24	36.9	4	6.2	3.2	64.3
12	ССАЖЗЯ	108	10	9.3	19	17.6	15	13.9	18	16.7	21	19.4	25	23.1	3.2	63.7
13	ЭЗХЯ	27	5	18.5	5	18.5	4	14.8	3	11.1	3	11.1	7	25.9	3.1	62.7
14	ЭМЯ	341	13	3.8	48	14.1	79	23.2	77	22.6	38	11.1	86	25.2	3.1	62.1
15	ХББОСЯ	72	4	5.6	14	19.4	16	22.2	16	22.2	4	5.6	18	25.0	2.9	58.8
16	БЯ	270	12	4.4	49	18.1	67	24.8	61	22.6	26	9.6	55	20.4	2.9	57.8
17	СЯ	52	9	17.3	11	21.2	10	19.2	8	15.4	1	1.9	13	25.0	2.9	57.7
18	ЭХЯ	79	9	11.4	16	20.3	19	24.1	12	15.2	4	5.1	19	24.1	2.9	57.4
	<b>НИЙТ</b>	<b>2302</b>	<b>-</b>	<b>7.7</b>	<b>-</b>	<b>13.1</b>	<b>-</b>	<b>17.3</b>	<b>-</b>	<b>18.1</b>	<b>-</b>	<b>14.5</b>	<b>-</b>	<b>29.3</b>	<b>3.3</b>	<b>66.3</b>

Энэ үзүүлэлтийн хувьд Батлан хамгаалах яам (76.5 хувь), Хууль зүй, дотоод хэргийн яам (76.0 хувь), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (73.3 хувь) хамгийн өндөр, харин Боловсролын яам (57.8 хувь), Сангийн яам (57.7 хувь), Эрчим хүчний яам (57.4 хувь) хамгийн бага үнэлгээ авчээ.

Ихэнх байгууллагад “сэтгэл ханамж дунд” болон “сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ давамгайлж байгаа нь үйлчилгээний мэдээлэл ерөнхийдөө ойлгомжтой ч сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Иймд цаашид мэдээллийг илүү товч, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, иргэдэд ээлтэй тайлбар, зааврыг сайжруулах, цахим болон уламжлалт сувгийг оновчтой ашиглах шаардлагатай юм.

### Асуудлыг шийдвэрлэх шат дамжлагад хэрэглэгчийн өгсөн үнэлгээ

Судалгааны “асуудал шийдвэрлэх шат дамжлага цөөн” үзүүлэлтийн (хүснэгт 5) судалгааны дундаж үнэлгээ 3.1, сэтгэл ханамжийн индекс 62.3 хувь байгаа нь төрийн захиргааны төв байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий индекс (66.7 хувь)-ээс доогуур байна.

Хүснэгт 5.Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шийдвэрлэх шат дамжлагад хэрэглэгчдийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултад эзлэх хувиар

	Байгууллагын нэр	Нийт	Хариулт												Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
			Мэдэхгүй-0		Огт санал нийлэхгүй-1		Сэтгэл ханамж багатай-2		Сэтгэл ханамж дунд-3		Сэтгэл ханамжтай-4		Сэтгэл ханамж маш өндөр-5			
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	ХЗДХЯ	360	40	11.1	24	6.7	51	14.2	78	21.7	48	13.3	119	33.1	3.6	71.7
2	БХЯ	336	30	8.9	18	5.4	53	15.8	96	28.6	36	10.7	103	30.7	3.5	70.0
3	ГХЯ	27	0	0.0	7	25.9	3	11.1	1	3.7	3	11.1	13	48.1	3.4	68.9
4	ЦХИХХЯ	45	3	6.7	7	15.6	4	8.9	9	20.0	9	20.0	13	28.9	3.4	68.1
5	ХХААХҮЯ	97	2	2.1	10	10.3	19	19.6	22	22.7	13	13.4	31	32.0	3.4	67.6
6	ГБХНХЯ	154	10	6.5	24	15.6	27	17.5	25	16.2	19	12.3	49	31.8	3.3	65.8
7	ЗГХХГ	60	1	1.7	6	10.0	17	28.3	12	20.0	6	10.0	18	30.0	3.2	64.4
8	ЗГХЭГ	43	2	4.7	2	4.7	10	23.3	13	30.2	9	20.9	7	16.3	3.2	64.4
9	ЗТЯ	84	6	7.1	12	14.3	16	19.0	15	17.9	13	15.5	22	26.2	3.2	64.4
10	ССАЖЗЯ	108	11	10.2	22	20.4	14	13.0	17	15.7	15	13.9	29	26.9	3.2	63.1
11	БОУАӨЯ	82	6	7.3	15	18.3	11	13.4	21	25.6	10	12.2	19	23.2	3.1	61.8
12	АҮЭБЯ	65	8	12.3	8	12.3	8	12.3	20	30.8	18	27.7	3	4.6	3.0	60.0
13	ЭМЯ	341	21	6.2	57	16.7	70	20.5	89	26.1	30	8.8	74	21.7	3.0	59.6
14	СЯ	52	8	15.4	10	19.2	13	25.0	8	15.4	2	3.8	11	21.2	2.8	55.9
15	ЭХЯ	79	6	7.6	19	24.1	17	21.5	17	21.5	4	5.1	16	20.3	2.7	54.8
16	ХББОСЯ	72	9	12.5	13	18.1	16	22.2	20	27.8	4	5.6	10	13.9	2.7	54.3
17	БЯ	270	11	4.1	75	27.8	55	20.4	59	21.9	21	7.8	49	18.1	2.7	53.4
18	ЭЗХЯ	27	5	18.5	8	29.6	3	11.1	5	18.5	1	3.7	5	18.5	2.6	52.7
	<b>НИЙТ</b>	<b>2302</b>	<b>-</b>	<b>7.9</b>	<b>-</b>	<b>16.4</b>	<b>-</b>	<b>17.6</b>	<b>-</b>	<b>21.3</b>	<b>-</b>	<b>12.0</b>	<b>-</b>	<b>24.7</b>	<b>3.1</b>	<b>62.3</b>

Хууль зүй, дотоод хэргийн яам (71.7 хувь), Батлан хамгаалах яам (70.0 хувь) өндөр үнэлгээ авсан бол Эдийн засаг, хөгжлийн яам (52.7 хувь) болон Боловсролын яам (53.4 хувь) хамгийн бага үнэлгээтэй байна.

Ихэнх байгууллагад “сэтгэл ханамж дунд” болон “сэтгэл ханамж багатай” гэсэн үнэлгээ давамгайлж, “сэтгэл ханамж маш өндөр” үнэлгээний хувь бага байгаа нь шат дамжлага цөөн биш, асуудлыг шийдвэрлэх үйл явц удаашралтай байгааг харуулж байна.

### Төрийн албан хаагчийн харилцаа хандлагад өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

Судалгаанд оролцогчид төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг 3.4 оноогоор “Дунд” гэж үнэлсэн бөгөөд сэтгэл ханамжийн индекс 67.7 хувь байна.

Хүснэгт 6.Төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчийн харилцаа хандлагад өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувь

Д/д	Байгууллагын нэр	Нийт	Хариулт												Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
			Мэдэхгүй-0		Огт санал нийлэхгүй-1		Сэтгэл ханамж багатай-2		Сэтгэл ханамж дунд-3		Сэтгэл ханамжтай-4		Сэтгэл ханамж маш өндөр-5			
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	ГХЯ	27	3	11.1	3	11.1	4	14.8	0	0.0	3	11.1	14	51.9	3.9	77.5
2	ХЗДХЯ	360	28	7.8	18	5.0	47	13.1	68	18.9	57	15.8	142	39.4	3.8	75.5
3	БХЯ	336	19	5.7	18	5.4	34	10.1	90	26.8	43	12.8	132	39.3	3.7	75.0

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

4	ХХААХҮЯ	97	2	2.1	13	13.4	9	9.3	16	16.5	17	17.5	40	41.2	3.7	73.1
5	ЗГХЭГ	43	0	0.0	3	7.0	3	7.0	12	27.9	14	32.6	11	25.6	3.6	72.6
6	БОУАӨЯ	82	3	3.7	10	12.2	12	14.6	16	19.5	9	11.0	33	40.2	3.6	71.6
7	ГБХНХЯ	154	9	5.8	15	9.7	22	14.3	29	18.8	23	14.9	56	36.4	3.6	71.4
8	ЦХИХХЯ	45	1	2.2	8	17.8	7	15.6	3	6.7	7	15.6	19	42.2	3.5	70.0
9	ССАЖЗЯ	108	9	8.3	14	13.0	14	13.0	22	20.4	21	19.4	28	25.9	3.4	67.1
10	ЗТЯ	84	10	11.9	11	13.1	11	13.1	16	19.0	16	19.0	20	23.8	3.3	66.2
11	ЭМЯ	341	11	3.2	44	12.9	63	18.5	82	24.0	38	11.1	103	30.2	3.3	65.6
12	АҮЭБЯ	65	4	6.2	6	9.2	11	16.9	16	24.6	21	32.3	7	10.8	3.2	63.9
13	ЗГХХГ	60	1	1.7	8	13.3	14	23.3	12	20.0	9	15.0	16	26.7	3.2	63.7
14	ХББОСЯ	72	7	9.7	10	13.9	15	20.8	18	25.0	4	5.6	18	25.0	3.1	61.5
15	БЯ	270	8	3.0	43	15.9	54	20.0	72	26.7	28	10.4	65	24.1	3.1	61.4
16	СЯ	52	7	13.5	9	17.3	12	23.1	6	11.5	3	5.8	15	28.8	3.1	61.3
17	ЭЗХЯ	27	3	11.1	5	18.5	3	11.1	8	29.6	2	7.4	6	22.2	3.0	60.8
18	ЭХЯ	79	8	10.1	12	15.2	17	21.5	19	24.1	5	6.3	18	22.8	3.0	60.0
	<b>НИЙТ</b>	<b>2302</b>	<b>-</b>	<b>6.5</b>	<b>-</b>	<b>12.4</b>	<b>-</b>	<b>15.6</b>	<b>-</b>	<b>20.0</b>	<b>-</b>	<b>14.6</b>	<b>-</b>	<b>30.9</b>	<b>3.4</b>	<b>67.7</b>

Үүнээс Батлан хамгаалах яам (75.0 хувь), Гадаад харилцааны яам (77.5 хувь), Хууль зүй, дотоод хэргийн яам (75.5 хувь) өндөр үнэлгээтэй бол Эдийн засаг, хөгжлийн яам (60.8 хувь), Эрчим хүчний яам (60.0 хувь) бага үнэлгээтэй байна.

Судалгаанд оролцогчдын хувьд “сэтгэл ханамжтай” болон “маш сайн” үнэлгээ зонхилж байгаа нь харилцааны соёл тодорхой хэмжээнд төлөвшсөнийг харуулж байна. Гадаад харилцааны яам, Зам тээврийн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамны хувь “мэдэхгүй” гэсэн хариулт 10-аас дээш хувь байна. Ерөнхийдөө “дунд” болон “бага” үнэлгээ 40 орчим хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

**Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварт өгсөн үнэлгээ**

Судалгаанд оролцогчид төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дунджаар 3.5 оноогоор үнэлсэн бөгөөд сэтгэл ханамжийн индекс 69.4 хувь байна. Энэ нь төрийн албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг хэрэглэгчид харьцангуй өндөр үнэлснийг харуулж байна.

Хүснэгт 7.Төрийн захиргааны төв байгууллагын төрийн албан хаагчийн мэдлэг ур, чадварт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ, хариултын тоо, хариултын нийт дүнд эзлэх хувиар

Д/д	Байгууллагын нэр	Хариулт														Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
		Нийт		Мэдэхгүй -0		Огт санал нийлэхгүй й-1		Сэтгэл ханамж багатай-2		Сэтгэл ханамж дунд-3		Сэтгэл ханамжта й-4		Сэтгэл ханамж маш өндөр-5			
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	БХЯ	336	18	5.4	7	2.1	39	11.6	83	24.7	45	13.4	144	42.9	3.9	77.6	
2	ХЗДХЯ	360	29	8.1	11	3.1	46	12.8	67	18.6	61	16.9	146	40.6	3.9	77.2	
3	ХХААХҮЯ	97	9	9.3	9	9.3	12	12.4	18	18.6	18	18.6	36	37.1	3.9	77.0	
4	ГХЯ	27	2	7.4	3	11.1	4	14.8	2	7.4	2	7.4	14	51.9	3.8	76.0	
5	ЗГХЭГ	43	1	2.3	2	4.7	4	9.3	11	25.6	11	25.6	14	32.6	3.7	74.8	
6	ГБХНХЯ	154	11	7.1	18	11.7	15	9.7	30	19.5	25	16.2	55	35.7	3.6	71.7	
7	БОУАӨЯ	82	7	8.5	8	9.8	13	15.9	14	17.1	7	8.5	33	40.2	3.6	71.7	
8	ЦХИХХЯ	45	2	4.4	6	13.3	6	13.3	8	17.8	6	13.3	17	37.8	3.5	70.2	
9	ЗТЯ	84	7	8.3	11	13.1	11	13.1	13	15.5	17	20.2	25	29.8	3.4	68.8	
10	ЭМЯ	341	12	3.5	37	10.9	55	16.1	85	24.9	36	10.6	116	34.0	3.4	68.4	
11	СЯ	52	7	13.5	7	13.5	10	19.2	6	11.5	2	3.8	20	38.5	3.4	68.0	
12	ЗГХХГ	60	2	3.3	5	8.3	11	18.3	16	26.7	8	13.3	18	30.0	3.4	67.9	
13	ССАЖЗЯ	108	9	8.3	15	13.9	16	14.8	16	14.8	19	17.6	33	30.6	3.4	67.9	
14	АҮЭБЯ	65	5	7.7	4	6.2	9	13.8	21	32.3	22	33.8	4	6.2	3.2	64.3	
15	ХББОСЯ	72	7	9.7	7	9.7	11	15.3	27	37.5	6	8.3	14	19.4	3.1	62.8	
16	ЭЗХЯ	27	3	11.1	6	22.2	1	3.7	8	29.6	2	7.4	7	25.9	3.1	62.5	
17	БЯ	270	14	5.2	44	16.3	51	18.9	63	23.3	33	12.2	65	24.1	3.1	61.9	
18	ЭХЯ	79	8	10.1	15	19.0	12	15.2	19	24.1	7	8.9	18	22.8	3.0	60.3	



	НИЙТ	2302	-	7.4	-	11.0	-	13.8	-	21.6	-	14.2	-	32.2	3.5	69.4
--	------	------	---	-----	---	------	---	------	---	------	---	------	---	------	-----	------

Батлан хамгаалах яам (77.6 хувь), Хууль зүй, дотоод хэргийн яам (77.2 хувь), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (77.0 хувь)-ны үнэлгээ өндөр бол Эдийн засаг, хөгжлийн яам (62.5 хувь), Эрчим хүчний яам (60.3 хувь), Боловсролын яам (61.9 хувь) бага үнэлгээтэй байна.

Мөн “сэтгэл ханамж багатай” болон “мэдэхгүй” гэсэн хариулт Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрчим хүчний яамны нийт хариултын 27.0-33.3 хувийг эзэлж байна.

### Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ

Төрийн захиргааны төв байгууллагуудын асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхийг хэрэглэгчид 3.3 оноо буюу “Дунд” гэж үнэлж, сэтгэл ханамжийн индекс 66.3 хувь байгаа нь төрийн захиргааны төв байгууллагын сэтгэл ханамжийн өрөнхий индекс (66.7 хувь)-ээс бага зэрэг бага байна.

Хүснэгт 8.Төрийн захиргааны төв байгууллагын асуудлыг шударга шийдвэрлэдэг эсэхэд хэрэглэгчийн өгсөн үнэлгээ, хариултын тоогоор болон нийт хариултын дүнд эзлэх хувиар

Д/д	Байгууллагын нэр	Нийт	Хариулт												Дундаж үнэлгээ	Сэтгэл ханамжийн индекс (хувь)
